



СҮХБААТАР АЙМГИЙН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/04

Баруун-Урт сум

Хүний нөөцийн стратеги төлөвлөгөө
(2024-2027 он) батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.9, 61 дүгээр зүйлийн 61.1.1, аймгийн Засаг даргын 2023 оны А/664 дүгээр захирамжийн хоёрдугаар хавсралтаар баталсан "Худалдан авах ажиллагааны газрын дүрэм"-ийн 2.3, Газрын даргын 2024 оны А/04 дүгээр тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 3.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын хүний нөөцийн стратеги төлөвлөгөө (2024-2027 он)-г хавсралтаар баталсугай.
2. Байгууллагын хүний нөөцийн стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, жил бүр үр дүнг тооцож ажиллахыг Хууль эрх зүй, дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн (Б.Галсанжамц)-д үүрэг болгосугай.

ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙН
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ө.ТАЙВАНСАНАА

2224010035